



БАТЛАВ.



БАТЛАВ.



БАТЛАВ.



2026 оны 06 сарын 05 ны өдөр

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.8-д “Усны хэмнэлттэй хэрэглээ, технологийг нэвтрүүлэх, ус, эрчим хүчний ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, газар тариалангийн усалгаанд газрын доорх усыг ашиглах болон хүнсний бус үйлдвэрлэлийн салбарт ундны цэвэр усыг ашиглах явдлыг хязгаарлах, хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх, цэвэршүүлсэн хаягдал ус болон саарал усыг дахин ашиглахыг бодлогоор дэмжинэ.” гэж усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх бодлогыг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр соёрхон баталсан “Мянганы сорилтын компакт гэрээ”-гээр дулааны гурав болон дөрөвдүгээр цахилгаан станцуудыг дахин ашиглах цэвэрлэсэн усаар хангах, үйлчилгээний төлбөр, тарифын зохицуулалтыг шинэчлэх, бодлогын болон эрх зүйн орчныг сайжруулан, бэхжүүлэх үүргийг Монгол Улсын Засгийн газар хүлээсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.3-т “Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.”, 6.3.1-д “Усны нөөцийн үнэ тарифт шатлан өсгөх зарчим тогтоож, усны хэрэглээг төлбөртэй болгон хэмнэлт, дахин ашиглалтыг нэмэгдүүлнэ.”, 9.2.3-т “Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулан, дахин ашиглаж, усны үнэ цэнийг нэмэгдүүлнэ.” гэж, Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.2-т “Хүн амын ус

хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хүртээмжтэй, тогтвортой, чанартай үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 2.4.3.6-т “саарал усыг дахин ашиглана” гэж, 3.4.1.7-д “усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Иймд дээрх хууль, Монгол улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг болон бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, хот, суурин газрын хүн амын унд-ахуйн усны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг урт хугацаанд, тогтвортой хангах зорилгоор Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага:

Гадаад харилцааны яамаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар, Мянганы Сорилтын Корпорацаар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс хооронд байгуулсан Мянганы сорилтын компакт гэрээний хүрээнд хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа буюу шинэ Төв цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усыг дахин боловсруулж, дулааны гурав болон дөрөвдүгээр цахилгаан станцуудад нийлүүлэх үйлдвэрийг холбогдох дэд бүтцийн хамт байгуулах төслийг бүрэн хэрэгжүүлэхэд дараах хүндрэл, бэрхшээл тулгарч байна. Үүнд:

1.Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиудад “ус дахин ашиглах”, “дахин ашиглах цэвэрлэсэн ус”-тай холбогдсон харилцааг зохицуулаагүй байх тул “цэвэрлэсэн усыг дахин ашиглах”, “дахин ашиглах усны эх үүсвэр” зэрэг нэр томьёо, хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрлэл, түүний дэд бүтэц, шугам хоолойн ашиглалт, хамгаалалт, хариуцлагын тогтолцоог бий болгох, дахин ашиглах цэвэрлэсэн усны үнэ тарифыг тогтоох эрх зүйн зохицуулалтгүй байна.

2.Дулааны гурав болон дөрөвдүгээр цахилгаан станцууд 2025 онд 14.7 сая.м³/жил (хоногт 40,300 тн) техникийн усыг хөргөх цамхаг, үнс тээвэрлэх ус, зуухны тэжээлийн ус, хотын сүлжээний нэмэлт ус, үйлдвэрлэлийн уур болон дотоод циклийн алдагдлыг нөхөх зэрэгт гүний цэвэр усыг өөрсдийн эзэмшлийн худгаас авч ашигласан бол 2044 онд энэ нь 17.8 сая.м³/жил (хоногт 49,000 тн) хүрэх тооцоолол гарсан.¹ Ингэснээр цаашид гүний цэвэр усны нөөцөд нөлөөлөх эрсдэл үүсч болзошгүй байна.

3.Улаанбаатар хотын унд ахуйн усны хэрэглээ хоногт 150-170 мян.м³ бөгөөд хотын ус хангамжийг газрын доорх усны 7 эх үүсвэрээс хангадаг. Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилт, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан нийт ус хангамжийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр алдагдаж, өсөн нэмэгдэж буй эрэлтийг найдвартай, тогтвортой хангах шинэ эх үүсвэр бий болгох, гүний усны нөөцийг хамгаалах, усыг дахин ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд 2030 он гэхэд хот ундны усны хомсдолтой тулгарах бодит эрсдэл нүүрлэх талаар Дэлхийн банкнаас 2024 онд хийсэн Монгол Улсад хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын зөвлөмжид дүгнэсэн байна.²

4.Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулж буй үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, ангилах ажлыг эрчимжүүлэх, үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэдэг байх шаардлагын биелэлтийг хангах зорилгоор усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай холбоотой хууль

¹ МСК Монгол Компакт II, Ус Дахин Боловсруулах Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тайлан, Улаанбаатар, 2018 он

² Монгол Улсад Хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын зөвлөмжүүд, Дэлхийн банк, 2024 он

тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Засгийн газрын болон нийслэлийн харьяа байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдэд ногдуулах торгууль, хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор бий болоод байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.Үүнд:

1.Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх, дахин ашиглах зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилтыг хуулийн зорилтод тусгана.

2.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн нэр томъёоны хэсэгт "дахин ашиглах цэвэрлэсэн ус", "дахин ашиглах усны эх үүсвэр" зэрэг нэр томъёог тайлбарлан тусгаж, эрчим хүчний болон хүнсний бус үйлдвэрлэлийн техникийн хэрэглээнд гүний ус ашиглахыг хязгаарлах, дахин ашиглах цэвэрлэсэн усыг нэн тэргүүнд ашиглах, эргэлтэд оруулдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

3.Дахин ашиглах цэвэрлэсэн усыг түгээх, дамжуулах, ашиглуулах харилцааг зохицуулах, хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шаардлагатай журам, стандартыг боловсруулж батлах, дахин ашиглах цэвэрлэсэн усыг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа эрхлэх төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно.

4.Дахин ашиглах цэвэрлэсэн усны үйлчилгээний төлбөр, тарифыг тогтоох, мөрдүүлэх эрхийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороонд олгох, мөн аж ахуйн нэгж, байгууллага хооронд хаягдал ус цэвэрлэх, боловсруулах, түүнийг дахин ашиглах тохиолдолд үйлчилгээний төлбөр, тарифыг талууд гэрээгээр тогтоох, тухайн гэрээг Зохицуулах хороо бүртгэх талаарх зохицуулалтыг тусгана.

5.Дахин ашиглах цэвэрлэсэн усны чанар, найрлагыг холбогдох стандартын дагуу тогтмол хянах тогтолцоог бүрдүүлэх, шаардлага хангаагүй ус хүлээн авахаас татгалзах, зөрчил гаргасан этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хуулийн хэрэгжилттэй холбоотой зохицуулалтыг батлах эрхийг Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллагад олгох эрх зүйн зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй бөгөөд нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Монгол Улсад анх удаа дахин ашиглах цэвэрлэсэн усны хэрэглээг нэвтрүүлэхтэй холбогдуулан эрх зүйн зохицуулалт, норм, дүрэм, стандартыг боловсронгуй болгох, эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглахад мөрдөх үйлчилгээний төлбөр, тарифыг тооцож тогтоох болон Улаанбаатар хотод шинээр байгуулагдах эрчим хүчний эх үүсвэрүүдэд дахин ашиглах цэвэрлэсэн усыг ашиглах эрх, зүйн орчин бүрдэнэ.

2.Компакт гэрээний хүрээнд "Нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр" амжилттай хэрэгжсэнээр Улаанбаатар хотын урт хугацааны ус хангамжийг ойролцоогоор жилд 64 сая шоо метрээр нэмэгдүүлж, нийслэл Улаанбаатар хотын хүн

амын унд-ахуйн усны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг урт хугацаанд тогтвортой хангах, эдийн засгийн ирээдүйн өсөлтийг дэмжих, хүн амын эрүүл мэнд, нийгмийн тогтвортой байдлын үндсэн суурийг бүрдүүлэх таатай нөхцөл бий болно.

3. Үйлдвэрлэлийн салбаруудад хаягдал усыг цэвэрлэж, дахин ашиглах, байгалийн цэнгэг усны нөөцийг хэмнэх, хаягдалгүй эдийн засаг (circular economy)-ийг хөгжүүлэх, бохирдуулагч төлөх зарчим хэрэгжих, үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилт биелэнэ.

4. Улаанбаатар хотын нийт усан хангамж бодитоор нэмэгдэж, улирлын хэлбэлзэл, олон жилийн хур тунадасны бууралт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэх эрсдэлийг багасгаж, барилга, үйлдвэрлэл, үйлчилгээ, нийтийн хангамжийн салбаруудын хүчин чадал өсөж, ажлын байр бий болох, татварын орлого нэмэгдэх, бизнес тасралтгүй өсөх нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн, усны эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал, зохисгүй хэрэглээ, чанаргүй эх үүсвэр нь нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, эрсдэл дагуулдаг байдлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

Хуулийн төслийг дагалдуулан Усны тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай, Барилгын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.